



## НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 209

Улаанбаатар хот

### ┌Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Нийслэлд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх журам”-ын нэмэлт, өөрчлөлтийг хавсралт ёсоор баталсугай.

2.Дээрх журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Д.Сумьяабазар/-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100650

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын  
30-ны өдрийн 229 дүгээр тогтоолын хавсралт



**“ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛЭЭР  
НИЙСЛЭЛД ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ”-ЫН  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**

1.Журамд дор дурдсан заалтуудыг нэмсүгэй:

**1/ 2<sup>1</sup>. ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

2<sup>1</sup>.1.Эрх бүхий этгээд нь Нийслэл Улаанбаатар хотын дэд бүтэц, нийгмийн суурь үйлчилгээ болон бусад чиглэлийн үйл ажиллагааг дэмжин хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх зорилгоор ТХХТ-ээр хэрэгжих төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулж болно.

2<sup>1</sup>.2.Эрх бүхий этгээд” гэж ТХХТ-ийн төсөл, хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, түншлэлийн гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий нийслэлийн байгууллагыг;

2<sup>1</sup>.3.Энэхүү журмын 2<sup>1</sup>.1 дэх хэсэгт заасан сонгон шалгаруулалтын журам аргачлалыг Эрх бүхий этгээд батална.

2/ 3.2.5.ТХХТ-ийн хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн талаар шийдвэр гаргах;

**3/ 4<sup>1</sup> ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ОЛГОСНЫ ТӨЛБӨР,  
БАРИМТ БИЧГИЙН ҮНЭ**

4<sup>1</sup>.1.ТХХТ-ээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх эрх авсан хуулийн этгээдээс эрх олгосны нэг удаагийн төлбөрийг Эрх бүхий этгээд авна;

4<sup>1</sup>.2.Төлбөр авахтай холбоотой асуудлыг ТХХТ-ийн гэрээнд талууд харилцан тохиролцож тусгана;

4<sup>1</sup>.3.Хэрэгжүүлэгчийг сонгох сонгон шалгаруулалтын баримт бичиг нь тодорхой үнэтэй байх бөгөөд уг үнийг Эрх бүхий этгээд тогтооно.

2.Журмын холбогдох хэсэг, заалтуудыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ Журмын 1.2.1 дэх хэсгийг “Нийслэлийн төсөв болон санхүүгийн төлөвлөгөөнд хэсэгчлэн болон бүрэн тусгагдаагүй, орон нутгийн засаг захиргаа дангаараа хэрэгжүүлэхэд технологийн шийдэл, санхүүгийн хувьд бэрхшээлтэй, ТХХТ зайлшгүй шаардлагатай байх” гэж;

2/ Журмын 1.2.6 дахь хэсгийг “Эдийн засаг, нийгмийн үр ашигтай байх” гэж;

3/ Журмын 2.1 дэх хэсгийг “Нийслэл Улаанбаатар хотод ТХХТ-ээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн талаарх саналыг тухайн асуудлыг хариуцсан

Нийслэлийн байгууллага болон гадаад, дотоодын хуулийн этгээд, иргэд нь Нийслэл Улаанбаатар хотод ТХХТ-ийн асуудал хариуцсан орон нутгийн өмчит хуулийн этгээдэд гаргана.” гэж;

4/ Журмын 2.2 дахь хэсгийг “Нийслэл Улаанбаатар хотод ТХХТ-ийн асуудал хариуцсан орон нутгийн өмчит хуулийн этгээд нь энэхүү журмын 2.1 дэх хэсэгт заасан саналыг хүлээн авч холбогдох тооцоо, судалгааг хийж ТХХТ-ээр хэрэгжих боломжтой эсэх талаар санал, шаардлагатай тохиолдолд дүгнэлт гаргана.” гэж;

5/ Журмын 2.3 дахь хэсгийг “Төсөл, хөтөлбөр нь ТХХТ-ээр хэрэгжих боломжтой тохиолдолд Нийслэл Улаанбаатар хотод ТХХТ-ийн асуудал хариуцсан орон нутгийн өмчит хуулийн этгээд нь санал, дүгнэлтээ Нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.” гэж;


6/ Журмын 2.4 дэх хэсгийг “Нийслэлийн Засаг дарга энэхүү журмын 2.3 дахь хэсэгт заасан санал, дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргана.” гэж;

7/ Журмын 3.1 дэх хэсгийг “Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх асуудлаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.”

8/ Журмын 4.4 дэх хэсгийг “Ажлын хэсгийн үйл ажиллагааг энэ журмаар зохицуулах бөгөөд уг журмаар зохицуулаагүй харилцааг Засгийн газрын 2012 оны 103 дугаар тогтоолоор баталсан уралдаант шалгаруулалтын болон санал үнэлэх журмаар зохицуулна.” гэж;

9/ Журмын 4.10.1.1 дэх хэсгийг “Ажлын хэсэг нь төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах баримт бичгийг Засгийн газрын 2012 оны 103 дугаар тогтоолоор батлагдсан жишиг баримт бичгийг харгалзан салбарын онцлог, тухайн төсөл хөтөлбөрийн төрөлд тохируулан боловсруулж Эрх бүхий этгээдээр батлуулна.” гэж;

10/ Журмын 4.11.1.5 дахь хэсгийг “хуулийн этгээд, түүний нэгдлээс өөрийн санаачилсан төсөл, хөтөлбөрийн техник, эдийн засгийн үндэслэл, зардал, ашгийн тооцоог хийсэн бөгөөд төсөл, хөтөлбөрийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөрөө санхүүжүүлэх боломжтой бол.” гэж.



3.Журмын 1.2.8 дахь заалтыг хассугай.